



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/86/НА-СТА-ТШЗ

Цахим www.audit.mn Баруун-Урт сум 2023 он	хуудас:	Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Ө.Золзаяа Утас: 70512123
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Албан шаардлага.....	16
5.2 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол шинж ухааны газар
ОУБайгууллагаас	Олон улсын байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.02.24 № 61
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ
1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Боловсролын үнэлгээний төвөөс тус сургуулийн багш нарыг БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу үнэлж, 1-4 дүгээр түвшинд үнэлэгдсэн 44 багшид Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд заасан мөнгөн урамшууллыг 10-25 хувиар бодож, үндсэн цалингаас тооцож олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг төлөвлөсөн ба БСУГ-ын үнэлгээгээр 3-р байр эзэлсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>150,765,480.99</u>	<u>153,697,304.73</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,229,256.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,229,256.19
3121	Төгрөг	-	1,229,256.19
31211	Төрийн сангийн харилцах	-	1,229,256.19
33	АВЛАГА	12,102,245.09	367,337.84
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,102,245.09	367,337.84
35	БАРАА МАТЕРИАЛ	138,663,235.90	152,100,710.70
351	Түүхий эд материал	83,524.00	59,461.70
35130	Эм боох материал	83,524.00	59,461.70
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	24,365,539.00	38,396,942.48
354	Хангамжийн материал	104,172,172.90	97,147,306.52
35410	Бичиг хэргийн материал	3,931,720.95	1,366,150.00
35420	Аж ахуйн материал	36,980,062.19	35,482,120.39
35430	Сэлбэг хэрэгсэл	702,000.00	260,000.00
35450	Барилгын засварын материал	1,917,600.00	250,000.00
35460	Хүнсний материал	1,080,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	59,560,789.76	59,789,036.13
35600	Мал амьтад	10,042,000.00	16,497,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,379,215,897.71</u>	<u>1,565,748,895.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,379,215,897.71	1,565,748,895.20
392	Биет хөрөнгө	1,036,795,897.71	1,221,853,895.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	826,587,184.74	826,587,184.74
39202	Хуримтлагдсан элэгдэл	(54,159,201.36)	(70,395,040.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,260,000.00	30,260,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19,760,000.00)	(22,760,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	387,023,100.07	301,676,497.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(322,319,492.37)	(71,286,037.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	304,520,032.69	235,068,270.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(211,951,907.01)	(112,139,082.04)
39209	Зам, гүүрийн байгууламж	13,000,000.00	13,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,499,999.80)	(7,799,999.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,500,000.00	10,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,500,000.00)	(10,500,000.00)
39217	Ном	90,096,180.75	99,642,101.47
393	Биет бус хөрөнгө	342,420,000.00	343,895,000.00
39301	Програм хангамж	-	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(25,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	345,929,860.00	344,350,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,509,860.00)	(1,930,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,529,981,378.70</u>	<u>1,719,446,199.93</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>22,638,780.53</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	22,638,780.53

413	Өглөг	-	22,638,780.53
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	9,028,780.53
4136	Бусад өглөг	-	13,610,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	13,610,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,529,981,378.70	1,696,807,419.40
51	Засгийн газрын хувь оролцоо	1,529,981,378.70	1,696,807,419.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,300,668,375.93	1,300,668,375.93
51101	Өмч: - төрийн	1,300,668,375.93	1,300,668,375.93
512	Хуримтлагдсан үр дүн	(1,067,449,406.35)	(900,623,365.65)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,072,098,046.28)	(2,585,328,539.96)
51220	Тайлант үеийн үр дүн	4,648,639.93	1,684,705,174.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,296,762,409.12	1,296,762,409.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,529,981,378.70	1,719,446,199.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,001,410,123.11	5,374,950,600.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,599,576.43	1,752,885,000.81
120	Нийтлэг татварын бус орлого	41,599,576.43	1,752,885,000.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,599,576.43	1,752,885,000.81
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	13,232,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	44,035,825.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	41,599,576.43	1,695,616,575.81
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,959,810,546.68	3,622,065,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,554,726,800.00	3,156,353,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	3,156,353,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,554,726,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,283,546.68	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,929,253.68	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,979,093.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,875,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	351,800,200.00	465,712,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	351,800,200.00	465,712,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,985,858,483.18	3,690,110,426.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,985,858,483.18	3,690,110,426.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,893,187,732.41	3,424,076,476.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,123,527,652.21	2,478,496,854.45
210101	Үндсэн цалин	1,164,693,763.40	1,593,013,755.28
210102	Нэмэгдэл	803,031,222.88	810,223,814.45
210104	Урамшуулал	155,802,665.93	75,259,284.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,793,158.82	309,342,636.19

210201	Тэтгэврийн даатгал	178,296,787.18	211,386,454.01
210202	Тэтгэмжийн даатгал	19,227,350.25	24,839,045.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,344,059.72	19,868,036.33
210204	Ажилгүйдлийн даатгал	4,188,397.54	5,155,246.62
210205	Эрүүл мэндийн даатгал	38,736,564.13	48,093,853.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,658,446.26	374,662,727.53
210301	Гэрэл, цахилгаан	4,436,648.66	6,606,868.38
210302	Түлш, халаалт	315,289,116.60	337,663,771.00
210303	Цэвэр, бохир ус	17,932,681.00	30,392,088.15
2104	Хангамж, бараа материалын зардал	28,274,586.49	-
210401	Бичиг хэрэг	5,133,333.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,265,699.60	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,176,556.40	-
210404	Ном, хэвлэл	8,840,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	460,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,398,797.49	-
2105	Нормативт зардал	6,860,036.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,232,536.00	-
210502	Хоол, хүнс	627,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,351,700.00	8,100,000.00
210604	Урсгал засвар	13,351,700.00	8,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	949,100.00	-
210702	Дотоод албан томилолт	949,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,031,674.00	31,349,099.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,031,674.00	13,232,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	18,116,499.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,741,378.63	222,125,158.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	103,957,237.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,730,796.00	41,146,879.85
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	72,010,582.63	77,021,041.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,670,750.77	266,033,949.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,161,920.30	265,751,853.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,495,020.30	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	85,666,900.00	265,751,853.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	507,393.73	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	507,393.73	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,436.74	282,096.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,436.74	282,096.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>15,551,639.93</u>	<u>1,684,840,174.31</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,903,000.00	135,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,669,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	9,234,000.00	135,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(10,903,000.00)	(135,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>4,648,639.93</u>	<u>1,684,705,174.31</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,959,810,546.68</u>	<u>3,679,334,025.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	57,268,425.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	57,268,425.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	57,268,425.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	13,232,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	44,035,825.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,959,810,546.68	3,622,065,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,554,726,800.00	3,156,353,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	3,156,353,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,554,726,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,283,546.68	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,929,253.68	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,979,093.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,875,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	351,800,200.00	465,712,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	351,800,200.00	465,712,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,936,008,366.68</u>	<u>3,561,074,768.81</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,936,008,366.68	3,561,074,768.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,839,973,577.21	3,298,901,972.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,116,429,648.60	2,466,761,947.20
210101	Үндсэн цалин	1,164,206,637.07	1,581,278,848.03
210102	Нэмэгдэл	796,787,134.48	810,223,814.45
210104	Урамшуулал	155,435,877.05	75,259,284.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	257,758,358.82	309,342,636.19
210201	Тэтгэврийн даатгал	178,296,787.18	211,386,454.01
210202	Тэтгэмжийн даатгал	19,227,350.25	24,839,045.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,344,059.72	19,868,036.33
210204	Ажилгүйдлийн даатгал	4,188,397.54	5,155,246.62
210205	Эрүүл мэндийн даатгал	37,701,764.13	48,093,853.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	340,754,763.26	368,415,100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,110,648.66	6,606,868.38
210302	Түлш, халаалт	317,711,433.60	337,663,771.00
210303	Цэвэр, бохир ус	17,932,681.00	24,144,460.62
2104	Хангамж, бараа материалын зардал	43,843,452.58	-
210401	Бичиг хэрэг	8,269,470.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,694,386.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,079,814.00	-
210404	Ном, хэвлэл	9,343,325.00	-

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	510,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,946,457.58	-
2105	Нормативт зардал	7,007,580.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,583,900.00	-
210502	Хоол, хүнс	795,480.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,628,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,135,720.00	5,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,376,120.00	-
210604	Урсгал засвар	20,759,600.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	949,100.00	-
210702	Дотоод албан томилолт	949,100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,297,100.00	35,641,299.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,297,100.00	13,232,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	22,408,699.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,797,853.95	113,740,989.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	84,997,889.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,797,853.95	28,743,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,034,789.47	262,172,796.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,525,959.00	261,890,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,779,059.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,746,900.00	261,890,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	507,393.73	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	507,393.73	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,436.74	282,096.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,436.74	282,096.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>23,802,180.00</u>	<u>118,259,256.19</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,802,180.00	117,030,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,802,180.00	117,030,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,802,180.00	117,030,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,802,180.00	117,030,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(23,802,180.00)</u>	<u>(117,030,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,229,256.19
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,229,256.19

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(1,067,449,406.35)	-	1,529,981,378.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(1,067,449,406.35)	-	1,529,981,378.70
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(1,067,449,406.35)	-	1,529,981,378.70
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(1,067,449,406.35)	-	1,529,981,378.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,517,879,133.61)	-	(1,517,879,133.61)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(2,585,328,539.96)	-	12,102,245.09
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,684,705,174.31	-	1,684,705,174.31
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(900,623,365.65)	-	1,696,807,419.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,691,404,100.0	3,677,822,672.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,691,404,100.0	3,677,822,672.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,429,513,400.0	3,415,931,972.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,467,982,000.0	2,466,761,947.2
210101	Үндсэн цалин	1,856,283,200.0	1,581,278,848.0
210102	Нэмэгдэл	543,962,800.0	810,223,814.5
210104	Урамшуулал	67,736,000.0	75,259,284.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	309,633,000.0	309,342,636.2
210201	Тэтгэврийн даатгал	210,886,200.0	211,386,454.0
210202	Тэтгэмжийн даатгал	24,686,600.0	24,839,045.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,749,300.0	19,868,036.3
210204	Ажилгүйдлийн даатгал	4,937,300.0	5,155,246.6
210205	Эрүүл мэндийн даатгал	49,373,600.0	48,093,853.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	368,415,100.0	368,415,100.0
210301	Гэрэл, цахилгаан	11,000,000.0	6,606,868.4
210302	Түлш, халаалт	338,730,900.0	337,663,771.0
210303	Цэвэр, бохир ус	18,684,200.0	24,144,460.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,000,000.0	22,000,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,000,000.0	17,000,000.0
210602	Тавилга	12,000,000.0	-
210604	Урсгал засвар	5,000,000.0	5,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,141,300.0	37,141,299.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,232,600.0	13,232,600.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,908,700.0	23,908,699.9

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	212,342,000.0	212,270,989.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176,478,900.0	176,407,889.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,863,100.0	35,863,100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,890,700.0	261,890,700.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	261,890,700.0	261,890,700.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	261,890,700.0	261,890,700.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,691,404,100.0	3,691,404,100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,225,692,000.0	3,225,692,000.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,225,692,000.0	3,225,692,000.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	465,712,100.0	465,712,100.0
122005	Орон нутгийн төсвөөс	465,712,100.0	465,712,100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,229,256.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль “Багш ажилтан бүр хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшил оролцоог бүх талаар дэмжин чанартай хүртээмжтэй, өндөр бүтээмжтэй сургалтыг тасралтгүй зохион байгуулахыг эрхэмлэнэ” гэсэн зорилгын хүрээнд иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал “Заавар батлах тухай”
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дугаар тушаал “Заавар батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189,464.8 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,229.2	1,229.2
Авлага	12,102.2	367.3	-11,734.9
Бараа материал	138,663.2	152,100.7	13,437.5
Үндсэн хөрөнгө	1,379,215.9	1,565,748.9	186,533.0
Нийт хөрөнгө	1,529,981.4	1,719,446.2	189,464.8
Өр төлбөр	-	22,638.8	22,638.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,529,981.4	1,696,807.4	166,826.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,529,981.4	1,719,446.2	189,464.8

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,229.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлээгүй нь нөлөөлжээ.
- Авлага дансны үлдэгдэл 11,734.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулсантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 152,100.7 мянган төгрөг болж 13,437.5 мянган төгрөгөөр өссөнд түрээсийн ном, мал амьтад дансны үлдэгдэл нөлөөлж байна.
- Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,565,748.9 мянган төгрөг болж, 186,533.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Сүхбаатар аймгийн ЗДТГ-аас англи хэлний кабинетийн сургалтын хэрэглэгдэхүүн 13,035.0 мянга, Баруун-Урт сумын ИТХ-аас гал тогооны тоног төхөөрөмж 17,000.0 мянга, БШУЯ-аас сурах бичиг 9,545.9 мянга, ширээ сандал 2,801.2 мянга, төгсөгчдөөс принтер, зурагт 1,035.0 мянга, УИХ-ын гишүүнээс зөөрийн компьютер 1,988.8 мянга, бусад 1,870.0 мянга нийт 47,275.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн хөрөнгө бүртгэж, БШУЯ-ны шийдвэрээр цахим танхим байгуулах зорилгоор тоног төхөөрөмж 89,910.0 мянга, 27,120.0 мянган төгрөгийн судлагдахууны хэрэглэгдэхүүн, тавилга эд хөрөнгө, биет бус хөрөнгө худалдан авчээ. Аймгийн ИТХ-н 2022 оны А/72 тоот тогтоолоор 120 нэр төрлийн 916 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа болон зах зээлийн үнэлгээгээр нэмэгдүүлсэн 147,614.4 мянга, нийт үндсэн хөрөнгө 247,073.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2022 оны 527 тоот албан бичгээр 31,098.1 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасаж, аймгийн ИТХ-ын 377,788.2 мянган төгрөгийн хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоож данс бүртгэлд бүртгэсэн нөлөөлжээ.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,696,807.4 мянган төгрөг болж 166,826.0 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,344,011.9 мянга, орон нутгаас 413,307.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг үндэслэн төсвийн төслийг 881,680.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,225,692.0 мянга, орон нутгийн төсвөөс 52,405.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 465,712.1 мянган төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг БШУЯ-аас санхүүжих 3,225,692.0 мянга, орон нутгийн санхүүжилт 465,712.1 мянга нийт 3,691,404.1 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 3,678,104.7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн санхүүжилтээс 282.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,229.2 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,678,104.7 мянган төгрөг буюу 99.6 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	9,563.5	9,563.5	-	100
2	80312- Сургалт семинар	4,781.7	4,780.8	0,9	99.9
3	81605- Эрүүл мэндийг дэмжих	10,998.0	10,998.0	-	100
4	81801- Үдийн цай хөтөлбөр	261,890.7	261,890.7	-	100
5	81806- Дотуур байрны үйлчилгээ	647.5	647.5	-	100
6	81816- Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	89,910.0	89,910.0	-	100
7	81823- Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	21,517.9	21,517.9	-	100
8	81834- Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2,576,249.0	2,576,023.8	225.2	99.9
9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	180,795.2	179,792.0	1,003.2	99.4
10	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургуулийн орчныг сайжруулах	3,760.0	3,690.0	70.0	98.1
11	81848- Сурах бичгийн түрээс	13,232.6	13,232.6	-	100
12	83602- ЗГ болон засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан.	42,500.0	30,500.0	12,000.0	71.7
13	83603-Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	9,845.9	9,845.8	0.1	100
14	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	373,415.1	373,415.1	-	100
15	80112-Нийтлэг үйлчилгээ	92,297.0	92,297.0	-	100
	НИЙТ	3,691,404.1	3,678,104.7	13,299.4	99.6

Батлагдсан төсвийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээний зарцуулалт гарчээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ө.Золзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 129 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 2,985,858.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,858.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад түлш халаалтын зардал 19,952.3 мянга, гэрэл цахилгаан зардал 1,496.2 мянга, цэвэр бохир усны зардал 6,211.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Байр ашиглалтын зардал: өмнөх оноос дунжаар 8.2 хувиар нэмэгдсэн нь өмнөх онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал бага гарсан бөгөөд тайланд онд үйл ажиллагаа хэвийн танхимаар хэрэгжсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэр, орлого зарлага мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Ерөнхий боловсролын лаборатори нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	8	28,328.0	8	28,328.0	100%
Төлбөрийн акт	5	12,525.6	5	12,525.6	100%
Зөвлөмж	1	-	1	-	100%
Нийт дүн	14	40,853.9	14	40,853.9	100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31,814.1 мянган төгрөгийн алдаа зөрчил³ илэрснээс 31,814.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.1 Албан шаардлага

- Үдийн хоолны зардалд батлагдсан төсвийг тус сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативаас 16,294.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.
- Хувь хүн, аж ахуйн нэгжээс барилгын материал, бичиг хэрэг, хүнс, ахуйн хэрэглээний материал худалдан авч 15,519.9 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайлан, тодруулгад илэрхийлж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах болон өр төлбөрийг зохистой удирдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/, Монгол улсын Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 237 дугаар тогтоолын 1 дэх /Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосуугай/ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөрийг нягтлан бодох бүртгэлд аккруэл сууриар хөтлөөгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" заалтад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөрийг нягтлан бодох бүртгэлд аккруэл сууриар хөтөлж, орлого зарлагыг гарсан тухай бүрд нь бүртгэж, санхүүгийн тайланд толилуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл							/мянган төгрөгөөр/
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/					Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
		Үүнээс	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үдийн хоолны 1 хүүхдэд ногдох нормативаас илүү зарцуулсан	1	16,294.2	-	-	1	16,294.2	-	-	-	-	-	-
Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж өр төлбөр үүсгэсэн	1	15,519.9	-	-	1	15,519.9	-	-	-	-	-	-
Сурах бичиг ашиглуулах үйлчилгээний төлбөрийг нягтлан бодох бүртгэлд аккруэл сууриар хөтлөөгүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	3	31,814.1	-	-	2	31,814.1	1	-	-	-	-	-
